

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/24/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он	Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261945 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Ц.Хосжаргал Утас: 261628 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Болор-Эрдэнэ Утас: 261740 Цахим хаяг: bolor-erdened@audit.gov.mn Аудитор: Б.Ариунжаргал Утас: 261740 Цахим хаяг: ariunjargalb@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.04.25 № 1143
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн нэгтгэсэн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 73,519.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, иж бүрэн, тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх, батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Тухайлбал:

- Санхүүгийн тайланд бүртгэлтэй 14,188.7 сая төгрөгийн олон жилийн насжилттай хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөс олгосон 6538 зээлдэгчийн 15,505.9 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн, гэрээний үүргийн биелэлт хангалтгүй;
- Санхүүгийн тайланд илэрхийлсэн 23,004.7 сая төгрөгийн авлага, 593.8 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 14,151.0 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээний гэрээний үүргийн биелэлт хангалтгүй, 9,111.3 сая төгрөгийн бүрэн хэрэгжиж дууссан барилга байгууламжийг улсын комисст хүлээлгэж өгч, ашиглагч байгууллагад шилжүүлээгүй;
- Жилийн эцэст 444.4 сая төгрөгийн бараа материал, 12,588.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгөд тооллого хийж, баталгаажуулаагүй, бүртгэлээр тавих хяналт хангалтгүй;
- Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 7,782.9 сая төгрөгийн эд хөрөнгөд дахин үнэлгээ хийгдээгүй;
- Гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй 7,157.6 сая төгрөг, анхан шатны баримтын бүрдэл дутуу 1,337.6 сая төгрөгийн ажил гүйлгээг бүртгэлд тусгасан;
- Худалдан авах ажиллагааны холбогдох журмыг зөрчиж 1,054.0 сая төгрөгийн худалдан авалт хийсэн, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулаагүй;
- Өмнөх аудитаар тогтоосон 148.1 сая төгрөгийн төлбөрийн акт, 7,386.3 сая төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй

зэрэг нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 5.1.4, 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, 12.2.1, 13 дугаар зүйлийн 13.7, 19 дүгээр зүйлийн 19.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 8.5, 34 дүгээр зүйлийн 34.1.3, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, 15.2.3 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны Б/26, 2020 оны Б/36, 2023 оны Б/03, Б/32, Б/45 дугаар 5 удаагийн тушаалаар 2019 оноос хойш Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр 5 албан тушаалтан, мөн Засгийн газрын 2016 оны 45, 2019 оны 32, 2020 оны 52 дугаар тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны Б/55, 2023 оны Б/02, Б/48, Б/03 дугаар тушаалаар 2019 оноос хойш Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр 6 албан тушаалтан тус тус томилогдож, хүний нөөцийн тогтвортой байдлын бодлого алдагдсан байна.

Аудитын гол асуудал

Улсын Их хурлын 2023 оны 46 дугаар тогтоол, Засгийн газрын 2023 оны 378 дугаар тогтоолоор “Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар” гэснийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар” гэж өөрчилж, харьяа 21 аймаг, Нийслэл болон 9 дүүрэг, нийт 31 төсөвт байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэж байгаа боловч Засгийн газрын 2012 оны “Төсвийн төвлөрүүлэн захирагчийг батлах тухай” 207 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт ороогүйгээс шалтгаалан төсвийн төвлөрүүлэн захирагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдээгүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 417 дугаар тогтоол, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 92 дугаар тогтоол, Өмчийн харилцааны газрын 2023 оны 3/962 дугаар албан бичгийг үндэслэн Мэргэжлийн хяналтын газар /хуучнаар/ татан буугдсантай холбоотойгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад 117 албан хаагчийн орон тоо нэмэгдэж, 23.9 сая төгрөгийн бараа материал, 978.3 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил шилжиж ирсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 207 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгаснаас гүйцэтгэлээр 157 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, 22 арга хэмжээ 90.0 хувь, 19 арга хэмжээ 70.0 хувь, 2 арга хэмжээ 50.0 хувь, 7 арга хэмжээ 30.0 хувь буюу нийт хэрэгжилт 93.8 хувьтай гэж тайлагнасан байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гараагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.ЗАГДЖАВ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	252,331,545.9	331,882,887.2
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	11,252,439.9	17,928,599.1
33	АВЛАГА	188,199,583.1	249,200,486.5
34	УРЬДЧИЛГАА	343,878.4	171,654.9
35	БАРАА МАТЕРИАЛ	8,006,602.1	9,299,699.6
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	44,529,042.3	55,282,447.1
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	142,665,583.2	152,999,190.8
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	142,665,583.2	152,999,190.8
39200	Биет хөрөнгө	129,982,397.6	138,708,805.0
39300	Биет бус хөрөнгө	12,683,185.6	14,290,385.8
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	394,997,129.1	484,882,078.0
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	31,669,686.5	24,258,668.2
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	19,976,238.7	21,534,504.1
41300	Өглөг	731,966.3	1,262,782.5
41400	Урьдчилж орсон орлого	19,244,272.3	20,271,721.6
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	11,693,447.8	2,724,164.1
42200	Урт хугацаат зээл	11,693,447.8	2,724,164.1
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	363,327,442.6	460,623,409.9
51	Засгийн газрын хувь оролцоо	363,327,442.6	460,623,409.9
51100	Засгийн газрын оруулсан капитал	50,126,917.8	50,327,827.0
51200	Хуримтлагдсан үр дүн	276,488,776.8	373,548,430.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	36,711,748.0	36,747,152.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	394,997,129.1	484,882,078.0

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,605,957,043.4	3,263,259,725.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	119,633,648.0	129,133,583.0
120	Нийтлэг татварын бус орлого	119,633,648.0	129,133,583.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,486,323,395.4	3,134,126,142.5
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,532,165,295.5	3,158,838,935.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,532,136,495.5	3,158,838,935.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	101,293,050.3	139,089,682.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	45,882,173.5	72,245,448.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,569,414.9	8,768,774.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,116,754.1	7,497,402.6
2104	Хангамж, бараа материалын зардал	3,348,447.3	3,962,586.1
2105	Нормативт зардал	5,931,154.6	5,995,554.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,478,014.2	1,098,992.4
2107	Томилолт, зочны зардал	473,676.3	797,093.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,215,865.6	22,189,980.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,277,549.6	16,533,849.4
212	ТАТААС	842,775,708.5	764,351,664.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	588,067,736.8	2,255,397,589.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	28,800.0	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	73,791,747.9	104,420,789.8
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	67,769.6	691.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	231,967,650.6	8,164,221.3
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(158,108,133.1)	96,257,259.5

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	518,103,554.5	518,103,554.5
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	3,353,599.9	3,353,599.9
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	521,457,154.4	521,457,154.4
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(23,492.7)	(23,492.7)
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	1,914.0	1,914.0
9	Тайлант үеийн үр дүн	(158,108,133.1)	(158,108,133.1)
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	363,327,442.6	363,327,442.6
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	977,504.6	977,504.6
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	364,304,947.2	364,304,947.2
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(34,474.7)	(34,474.7)
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	96,185.0	96,185.0
19	Тайлант үеийн үр дүн	96,257,259.5	96,257,259.5
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	460,623,409.9	460,623,409.9

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,632,015,294.4	3,319,665,641.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	129,654,674.9	149,140,020.1
120	Нийтлэг татварын бус орлого	129,654,674.9	149,140,020.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,502,360,619.5	3,170,525,621.6
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,588,540,821.4	3,291,000,743.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,588,540,821.4	3,291,000,743.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	88,807,962.4	125,562,935.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	45,504,196.3	71,498,512.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,642,654.5	8,758,473.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,993,655.4	7,561,734.7
2104	Хангамж, бараа материалын зардал	2,388,203.3	2,700,658.0
2105	Нормативт зардал	5,642,836.1	6,254,373.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,428,844.2	1,222,976.0
2107	Томилолт, зочны зардал	451,846.6	792,202.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,261,322.8	23,105,534.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,494,403.0	3,668,469.5
212	ТАТААС	843,275,708.5	764,989,010.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	656,457,150.5	2,400,448,797.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	43,474,473.1	28,664,898.2
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	19,660,793.6	21,968,739.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	19,660,793.6	21,968,739.9
2200	Дотоод эх үүсвэрээр	19,660,793.6	21,968,739.9
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(19,660,793.6)	(21,968,739.9)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(20,003,583.2)	(19,999.1)
14	Бусад эх үүсвэр	16,480.5	67.3
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	20,000,000.0	-
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	20,063.6	20,066.4
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	3,810,096.3	6,676,159.2
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	7,442,343.6	11,252,439.9
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	11,252,439.9	17,928,599.1

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,244,022,184,900.00	3,092,459,975,394.04	151,562,209,505.96	95.3
УРСГАЛ ЗАРДАЛ	3,207,180,926,200.00	3,057,397,406,790.42	149,783,519,409.58	95.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	125,071,384,500.00	113,174,979,679.01	11,896,404,820.99	90.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	74,693,976,900.00	68,762,273,518.15	5,931,703,381.85	92.1
Үндсэн цалин	43,029,481,700.00	38,941,287,122.84	4,088,194,577.16	90.5
Нэмэгдэл	23,901,970,100.00	17,263,601,275.98	6,638,368,824.02	72.2
Унаа хоолны хөнгөлөлт	3,869,873,000.00	6,678,017,099.57	(2,808,144,099.57)	172.6
Урамшуулал	3,817,352,100.00	5,811,544,259.20	(1,994,192,159.20)	152.2
Гэрээт ажлын хөлс	75,300,000.00	67,823,760.56	7,476,239.44	90.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,647,498,700.00	8,509,092,364.47	1,138,406,335.53	88.2
Тэтгэврийн даатгал	6,599,421,500.00	5,876,498,826.57	722,922,673.43	89.0
Тэтгэмжийн даатгал	762,041,100.00	678,630,808.84	83,410,291.16	89.1
ҮОМШӨ-ний даатгал	609,633,000.00	538,242,684.31	71,390,315.69	88.3
Ажилгүйдлийн даатгал	152,507,500.00	131,572,456.07	20,935,043.93	86.3
Эрүүл мэндийн даатгал	1,523,895,600.00	1,284,147,588.68	239,748,011.32	84.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,944,643,500.00	7,349,628,111.76	595,015,388.24	92.5
Гэрэл, цахилгаан	1,674,195,500.00	1,379,527,761.68	294,667,738.32	82.4
Түлш, халаалт	4,279,498,000.00	4,132,421,491.35	147,076,508.65	96.6
Цэвэр, бохир ус	769,635,900.00	612,033,945.21	157,601,954.79	79.5
Байрны түрээс	1,221,314,100.00	1,225,644,913.52	(4,330,813.52)	100.4
Хангамж, бараа материалын зардал	1,644,000,600.00	1,552,366,265.75	91,634,334.25	94.4
Бичиг хэрэг	282,053,400.00	275,702,805.52	6,350,594.48	97.7
Тээвэр, шатахуун	360,620,700.00	339,523,404.66	21,097,295.34	94.1
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	266,725,400.00	249,512,550.05	17,212,849.95	93.5
Ном, хэвлэл	600,000.00	-	600,000.00	0.0
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	78,869,600.00	66,249,859.00	12,619,741.00	84.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	655,131,500.00	621,377,646.52	33,753,853.48	94.8
Нормативт зардал	5,694,746,500.00	5,462,418,151.06	232,328,348.94	95.9
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,079,781,300.00	1,034,263,364.59	45,517,935.41	95.8
Хоол, хүнс	3,909,582,200.00	3,755,648,040.47	153,934,159.53	96.1
Нормын хувцас, зөөлөн эдлэл	705,383,000.00	672,506,746.00	32,876,254.00	95.3
Эд хогшил, урсгал засварын зардал	867,483,600.00	804,416,005.44	63,067,594.56	92.7
Багаж, техник, хэрэгсэл	225,715,300.00	194,645,693.98	31,069,606.02	86.2
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	20,956,600.00	10,956,400.00	10,000,200.00	52.3
Урсгал засвар	620,811,700.00	598,813,911.46	21,997,788.54	96.5
Томилолт, зочны зардал	218,372,100.00	208,002,740.95	10,369,359.05	95.3
Гадаад албан томилолт	49,134,000.00	49,134,000.00	-	100.0
Дотоод албан томилолт	164,936,000.00	154,837,570.95	10,098,429.05	93.9
Зочин төлөөлөгч хүлээн авах	4,302,100.00	4,031,170.00	270,930.00	93.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,058,096,100.00	20,235,721,360.22	3,822,374,739.78	84.1
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,375,092,300.00	19,735,091,211.29	3,640,001,088.71	84.4
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	170,284,700.00	164,366,950.00	5,917,750.00	96.5
Даатгалын үйлчилгээ	96,103,400.00	89,113,439.59	6,989,960.41	92.7
Тээврийн хэрэгслийн татвар	24,088,600.00	20,144,755.60	3,943,844.40	83.6

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Тээврийн хэрэгслийн оношилгоо	4,818,700.00	3,191,932.00	1,626,768.00	66.2
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	129,818,100.00	124,351,271.94	5,466,828.06	95.8
Газрын төлбөр	57,042,000.00	50,525,782.00	6,516,218.00	88.6
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	4,367,600.00	2,132,052.80	2,235,547.20	48.8
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	196,480,700.00	46,803,965.00	149,676,735.00	23.8
Бараа үйлчилгээний бусад зардал	302,566,500.00	291,061,161.21	11,505,338.79	96.2
Бараа үйлчилгээний бусад зардал	112,846,600.00	111,774,967.00	1,071,633.00	99.1
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	189,719,900.00	179,286,194.21	10,433,705.79	94.5
ТАТААС	775,007,875,300.00	764,992,410,072.04	10,015,465,227.96	98.7
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	775,007,875,300.00	764,992,410,072.04	10,015,465,227.96	98.7
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	775,007,875,300.00	764,992,410,072.04	10,015,465,227.96	98.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,307,101,666,400.00	2,179,230,017,039.37	127,871,649,360.63	94.5
Засгийн газрын урсгал шилжүүлэг	7,262,578,400.00	2,780,497,830.96	4,482,080,569.04	38.3
Засгийн газрын дотоод шилжүүлэг	7,001,959,600.00	2,599,978,905.67	4,401,980,694.33	37.1
Засгийн газрын гадаад шилжүүлэг	260,618,800.00	180,518,925.29	80,099,874.71	69.3
Бусад урсгал шилжүүлэг	2,299,839,088,000.00	2,176,449,519,208.41	123,389,568,791.59	94.6
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	2,207,704,749,800.00	2,117,874,594,032.45	89,830,155,767.55	95.9
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	133,595,300.00	132,809,800.00	785,500.00	99.4
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	90,078,565,900.00	56,754,368,814.86	33,324,197,085.14	63.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,681,346,700.00	1,464,868,671.30	216,478,028.70	87.1
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	240,830,300.00	222,877,889.80	17,952,410.20	92.5
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	36,841,258,700.00	35,062,568,603.62	1,778,690,096.38	95.2
Барилга байгууламж	30,175,649,100.00	28,446,908,266.62	1,728,740,833.38	94.3
Их засвар	5,632,909,600.00	5,598,235,427.00	34,674,173.00	99.4
Тоног төхөөрөмж	1,032,700,000.00	1,017,424,910.00	15,275,090.00	98.5
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,244,022,184,900.00	3,207,567,916,988.00	36,454,267,912.00	98.9
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,140,371,906,800.00	3,024,175,560,984.29	116,196,345,815.71	96.3
Улсын төсвөөс санхүүжих	3,140,371,906,800.00	3,024,175,560,984.29	116,196,345,815.71	96.3
НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	798,372,400.00	1,113,541,900.00	(315,169,500.00)	139.5
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	798,372,400.00	1,113,541,900.00	(315,169,500.00)	139.5
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	94,851,905,700.00	146,092,519,416.64	(51,240,613,716.64)	154.0
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	34,160,888,400.00	90,585,892,678.09	(56,425,004,278.09)	265.2
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,307,458,000.00	8,706,026,307.60	(3,398,568,307.60)	164.0
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	55,383,559,300.00	46,800,600,430.95	8,582,958,869.05	84.5
БУСАД ЭХ ҮҮСВЭР	8,000,000,000.00	36,186,294,687.07	(28,186,294,687.07)	452.3
Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	8,000,000,000.00	36,186,294,687.07	(28,186,294,687.07)	452.3
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	9,832,290,010.55	(9,832,290,010.55)	-

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	14,509,163,926.25	(14,509,163,926.25)	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	84	84	-	100.0
Төсвийн байгууллага	84	84	-	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	3,700	3,608	92	97.5
Удирдах ажилтан	117	117	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	2,779	2,696	83	97.0
Үйлчлэх ажилтан	804	795	9	98.9

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	28,986,933,220.43
УРСГАЛ ЗАРДАЛ	-	27,977,003,388.45
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	17,661,506,253.27
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	2,744,461,519.80
Үндсэн цалин	-	654,421,868.95
Нэмэгдэл	-	1,208,383,308.96
Унаа хоолны хөнгөлөлт	-	45,988,006.30
Урамшуулал	-	302,774,094.56
Гэрээт ажлын хөлс	-	532,894,241.03
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	249,381,009.13
Тэтгэврийн даатгал	-	202,928,533.89
Тэтгэмжийн даатгал	-	12,794,817.78
ҮОМШӨ-ний даатгал	-	10,509,802.39
Ажилгүйдлийн даатгал	-	2,110,406.33
Эрүүл мэндийн даатгал	-	21,037,448.74
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	194,984,649.17
Гэрэл, цахилгаан	-	39,331,393.11
Түлш, халаалт	-	90,801,341.92
Цэвэр, бохир ус	-	27,100,664.14
Байрны түрээс	-	37,751,250.00
Хангамж, бараа материалын зардал	-	1,159,219,885.65
Бичиг хэрэг	-	326,135,113.60
Тээвэр, шатахуун	-	470,368,071.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	55,708,711.05
Ном, хэвлэл	-	91,334,996.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	10,456,150.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	205,216,844.00
Нормативт зардал	-	822,229,644.74
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	24,421,153.42
Хоол, хүнс	-	718,245,041.32
Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	79,563,450.00
Эд хогшил, урсгал засварын зардал	-	687,829,975.58
Багаж, техник, хэрэгсэл	-	191,015,913.00
Тавилга	-	50,815,300.00
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	962,500.00
Урсгал засвар	-	445,036,262.58
Томилолт, зочны зардал	-	584,200,133.14
Гадаад албан томилолт	-	15,600,400.00
Дотоод албан томилолт	-	568,599,733.14
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	7,873,929,754.70
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	7,848,235,262.70
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	2,217,600.00
Даатгалын үйлчилгээ	-	501,860.00
Тээврийн хэрэгслийн татвар	-	1,216,433.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	516,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	12,603,600.00
Газрын төлбөр	-	2,669,299.00
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	5,969,700.00
Бараа үйлчилгээний бусад зардал	-	3,345,269,681.36
Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,373,858,314.85
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	971,411,366.51
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	10,315,497,135.18
Бусад урсгал шилжүүлэг	-	8,183,154,053.00
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	-	7,613,112,438.00

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	56,466,000.00
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	1,942,000.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	511,633,615.00
Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	2,132,343,082.18
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,930,125,674.83
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	4,056,000.00
Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	198,161,407.35
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	1,009,929,831.98
Дотоод эх үүсвэрээр	-	1,009,929,831.98
Тоног төхөөрөмж	-	61,000,000.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	948,929,831.98
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	28,986,933,220.43
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	28,986,933,220.43
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	4,106,772,674.02
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	3,463,056,278.32
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	8,856,270,537.67
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	10,806,873,855.84
Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	-	1,753,959,874.58
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 28,403.1 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 185 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан.

Аудитаар нийт 73,305.7 сая төгрөгийн 352 зөрчил² илэрснээс, 306.6 сая төгрөгийн 55 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 32,605.6 сая төгрөгийн 109 зөрчилд албан шаардлага хүргүүлж, үүнээс 22,892.3 сая төгрөгийн 7 хариуцлага тооцох албан шаардлага, 40,393.5 сая төгрөгийн 188 зөрчилд зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй зөрчлийн дүн 73,305.7 сая төгрөг нь тогтоосон материаллаг байдлын түвшин 32,684.0 сая төгрөгөөс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

3.1 Харьяа байгууллагууд

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 155 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэн аудитад хамруулсан.

Аудитаар 86 байгууллагын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй”, 25 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгч, Дорнод аймгийн ГБХЗХГ-ын санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан, аудитын түүвэрт 37 байгууллага, 3 зардлын данс, 3 төсөл, хөтөлбөрийн нэгжийг хамрууллаа.

Харьяа байгууллагуудад хийсэн аудитаар 28,403.1 сая төгрөгийн 185 алдааг залруулж, 73,278.7 сая төгрөгийн 348 зөрчил илэрсэн нь өмнөх оноос 48.1 хувиар буюу 35,249.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

“Хязгаарлалттай” дүгнэлт болон дүгнэлт өгөхөөс татгалзсан, харьяа байгууллагын санхүү, төсвийн үйл ажиллагаанд анхаарч, нэгжийн дотоод хяналтыг сайжруулж ажиллах шаардлагатай байгааг харуулж байна.

3.2 Төсвийн ерөнхийлөн захирагч

Аудитаар илэрсэн 27.0 сая төгрөгийн 2 зөрчил илрүүлж, 27.0 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, төсөвт байгууллагын дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх талаар 1 албан шаардлага хүргүүллээ.

Төлбөрийн акт:

Олон улсын Найрамдал цогцолборын төв байрны их засварын 37.0 сая төгрөгийн гэрээт ажлын санхүүжилтийг бүрэн олгосон боловч ажил хийж гүйцэтгээгүй гэрээ цуцлагдаж, барагдуулаагүй үлдэгдэл 27.0 сая төгрөг 2015 оноос хойш одоог хүртэл урьдчилж төлсөн зардлын дансанд бүртгэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-д "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.2-д "төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээт ажлыг хийж гүйцэтгээгүй, урьдчилж олгосон санхүүжилтийн үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох.

Албан шаардлага:

ХНХС-ын харьяа байгууллагуудад санхүүгийн тайлангийн аудитаар нийт 73,278.7 сая төгрөгийн 348 зөрчил илэрснээс, 279.6 сая төгрөгийн 54 төлбөрийн акт тогтоож, 32,605.6 сая төгрөгийн 109 албан шаардлага, үүнээс 22,892.3 сая төгрөгийн 7 зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлж, 365.3 сая төгрөгийн зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 40,393.5 сая төгрөгийн 188 зөвлөмж хүргүүлсэн, нийт залруулагдаагүй алдаа, зөрчлийн 63.7 хувь буюу 46,680.7 сая төгрөг нь ХЭДС-ийн зөрчил эзэлж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.11-д "төсөв, санхүүгийн дотоод аудит, хяналт шалгалтыг зохион байгуулж, удирдлагаар хангах", 14 дүгээр зүйлийн 14.2.10-д "өөрийн эрхлэх

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх.” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 19 дүгээр зүйлийн 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эрсдэлд суурилсан дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө боловсруулж, батлуулан гүйцэтгэх, харьяа байгууллагад илэрсэн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

3.3 Аудитын түүвэрт хамрагдсан байгууллагуудад илэрсэн алдаа, зөрчил

3.3.1 ХНХЯ-ны хөрөнгө оруулалт

ХНХЯ-ны хөрөнгө оруулалтын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 9,111.3 сая төгрөгийн 2 зөрчил илэрснээс, гэрээний үүргийн биелэлт хангалтгүй хөрөнгө оруулалтын ажилд 1 зөрчилд албан шаардлага, алдаа, зөрчлийг арилгах, цаашид давтан гаргахгүй байх 9,111.3 сая төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

Албан шаардлага:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022-2023 онд хэрэгжүүлж дуусгах Олон улсын хүүхдийн Найрамдал зуслангийн их засвар, тохижилтын ажил 8,288.3 сая төгрөгийн, Сүхбаатар дүүргийн хүүхэд, залуучуудын ногоон бүсийн зуслангийн ажил 4,562.7 сая төгрөгийн, 2020-2023 онд хэрэгжиж дуусах Сүхбаатар дүүргийн хүүхэд, залуучуудын ногоон бүсийн зуслангийн тохижилт, тоног төхөөрөмж нийлүүлэх 1,300.0 сая төгрөгийн, нийт 14,151.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг гэрээнд заасан хугацаанд хийж гүйцэтгэн хүлээлгэж өгөөгүй, гэрээний үүргийн биелэлт хангалтгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах;”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 19 дүгээр зүйлийн 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн гэрээний үүргийн биелэлтийг хангаж ажиллаагүй, төсөл, арга хэмжээний биелэлтийг хангаж ажиллах, илэрсэн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн оруулав. Үүнд:

Илрүүлэлт:

БНХАУ-ын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр баригдсан 2022 онд бүрэн хэрэгжиж дууссан 9,111.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төвийн барилга" байгууламжийг улсын комисст хүлээлгэж өгөөгүй, бусад эргэлтийн хөрөнгийн дансанд бүртгэлтэй хэвээр байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах;”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 19 дүгээр зүйлийн 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Бүрэн хэрэгжиж дууссан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг улсын комисст хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулж, ашиглагч байгууллагад шилжүүлэх.

3.3.2 ХНХЯ-ны хөрөнгө оруулалтын техник хяналтын зардал

ХНХЯ-ны хөрөнгө оруулалтын техник хяналтын зардлын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар 6.3 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

Төлбөрийн акт:

Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын бүрэн хэрэгжиж дууссан Иргэдийн хөгжлийн төвийн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 12 дугаар хороо/ байгууламжийн төсөл, арга хэмжээний зохиогчийн хяналтын зардлын зарцуулагдаагүй 6.3 сая төгрөгийн үлдэгдлийг улсын төсөвт буцаан төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ.", 45 дугаар зүйлийн 45.2-д "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.2-д "төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бүрэн хэрэгжсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зарцуулагдаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн оруулав. Үүнд:

3.3.3 ХНХЯ-ны хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн данс:

ХНХЯ-ны хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар 593.8 сая төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өгсөн.

Урьдчилгаа данстай холбоотой асуудал

